



**ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2024 оны 02 сарын 09 өдөр

Дугаар A/86

Баян-Өндөр сум

**"Эмч" хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2024 оны жилийн
төлөвлөгөө, төсвийг батлах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, Эрүүл мэндийн тухай хуулийн 11.1.1, 11.1.2, 11.1.3, 11.1.7, 11.2.4, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн "Аймгийн 2024 оны төсөв батлах тухай" 17/04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1."Эмч" хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2024 оны жилийн төлөвлөгөө, төсвийг хавсралтаар баталсугай.

2.Зардалд шаардагдах 130,000,000 (Нэг зуун гучин сая) төгрөгийг Төсөл хөтөлбөрийн зардлын Эрүүл мэндийн ажилтны нийгмийн асуудлыг дэмжих "Эмч" хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх зардал"-аас гаргаж, батлагдсан төсөвт багтаан санхүүжүүлж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс ((Л.Галсансайнхувьт)-т зөвшөөрсүгэй.

3.Батлагдсан төсвийг үр дүнтэй зарцуулж, тайлагнаж ажиллахыг Эрүүл мэндийн газар (Д.Сүхээ)-т үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (А.Бумансор)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ



М.ТҮМЭНЖАРГАЛ

Аймгийн Засаг даргын 2024 оны
02 дугаар сарын ...-ны өдрийн
А/Аб. дүгээр захирамжийн хавсралт

“ЭМЧ” ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ 2024 ОНЫ ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хэрэгжилтийг хариуцах байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага	Санхүүгийн эх үүсвэр
1.	Эмч эмнэлгийн мэргэжилтнийг төгсөлтийн дараах мэргэшүүлэх сургалтад хамруулах. Үүнд: -Өрхийн эмч сувилагч нарын ажлын байрны сургалт -Ахмадын эмч нарыг чадавхжуулах	Төгсөлтийн дараах үндсэн мэргэжлийн сургалтад хамрагдсан эмч, эмнэлгийн мэргэжилтний эзлэх хувь	79%	80%	ЭМГ	ЗДТГ, эрүүл мэндийн байгууллагууд	1,500.000
2.	Орон нутагт нэн шаардлагатай байгаа мэргэшүүлэх сургалтад хамрагдахад нийгмийн хариуцлагын гэрээ байгуулж дэмжлэг үзүүлэх. Үүнд: -Сувилахуйн эмнэл зүйн сургагч багш бэлтгэх сургалт зохион байгуулах	Нэн шаардлагатай мэргэжил эзэмшсэн эмч, эмнэлгийн мэргэжилтний эзлэх хувь	81%	90%	ЭМГ	ЗДТГ, эрүүл мэндийн байгууллагууд	2,000.000
3.	Эмч, сувилагч эмнэлгийн тусгай мэргэжилтнүүдийн дунд эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах	Судалгаа шинжилгээ хийсэн эмч, эмнэлгийн мэргэжилтний эзлэх хувь	19.5%	20%	ЭМГ	ЗДТГ, эрүүл мэндийн байгууллагууд	2,000.000
4.	Мэргэжлийн зэрэг ахиулахад дэмжлэг үзүүлэх	Мэргэжлийн зэрэгтэй эмчийн эзлэх хувь	27.6%	27.7%	ЭМБ-ууд	Эрүүл мэндийн байгууллагууд	Тухайн байгууллагын төсөв
5.	Өндөр хөгжилтэй оронд мэргэжил дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх. Үүнд: -Сингапур улс	Боловсролын зэрэгтэй эмчийн эзлэх хувь	13.2%	13.3%	ЭМГ, ЭМБ-ууд	ЗДТГ, гадаад, дотоодын их дээд сургуулиуд	9,000.000
6.	Гадаад улсад бэлтгэгдсэн эмч мэргэжилтэн өөрийн мэдлэг туршлагаа түгээн дэлгэрүүлэхийг дэмжих	Мэдлэг туршлагаа дэлгэрүүлсэн	2	2	ЭМГ, ЗДТГ	Эрүүл мэндийн байгууллагууд	7,000.000

	-Ходоодны дурангийн хагалгаа -Хөхний MRI шинжилгээ	эмч мэргэжилтний тоо	72	75	ЭМГ	ЗДТГ Эрүүл мэндийн байгууллагууд	Тухайн байгууллагын төсөв
7.	Орчин үеийн техник технологи ашиглах болон техникчийг чадавхжуулах	Суралцсан эрүүл мэндийн ажилтны тоо	72	75	ЭМГ	ЗДТГ Эрүүл мэндийн байгууллагууд	Тухайн байгууллагын төсөв
8.	Гадаад, дотоодын эмч нартай ажил мэргэжлийн туршлага солилцох буюу БНСУ-ын Дэгү хотын эрүүл мэндийн байгууллагатай хамтран ажиллах	Сэлгэн ажилласан эмчийн тоо	2	3	ЭМГ	ЗДТГ, Эрүүл мэндийн байгууллагууд, хандивлагч орнууд	Бусад эх үүсвэр
9.	Эрүүл мэндийн "Анагаах увдис" сэтгүүлийг хэвлүүлэхэд дэмжлэг үзүүлэх	Хэвлүүлсэн сэтгүүлийн тоо	200	200	ЭМГ	ЗДТГ, Эрүүл мэндийн байгууллагууд	6,500,000
10.	Нарийн мэргэжлийн эмч нарын зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулах. Үүнд: -Уламжлалт анагаах ухааны чуулган зохион байгуулах -Эрүүл мэндийн салбарын удирдах ажилтны зөвлөгөөн -Дэлхийн эмч нарын баярын хурал -Олон улсын сувилагчдын баярын хурал -"Судлаач эмч, мэргэжилтэн" клуб ажиллуулах -"Миний мэргэжил-миний бахархал- Би сувилагч" ур чадварын уралдаан -"Бид дорнын анагаах ухааны эмч" ур чадварын уралдаан -"Би эмч" ур чадварын уралдаан тэмцээн	Уулзалт зөвлөгөөний тоо	2	1	ЭМГ	ЗДТГ, Эрүүл мэндийн байгууллагууд	65,000,000
11.	Эрүүл мэндийн ажилтны ёс зүйг хувь хүний хандлагад тулгуурлан төлөвшүүлэх сургалтыг зохион байгуулах	Бүртгэгдсэн ёс зүйн зөрчил	-	-	Эмнэлгийн мэргэжилтни ёс зүйн хороо	ЭМГ, Эрүүл мэндийн байгууллагууд	Бусад эх үүсвэр, терийн болон хувийн хэвшлийн ЭМБ-ууд

12.	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдал байгууллагын хөгжил удирдлага төлөвлөлт зохион байгуулалтыг сайжруулах зорилгоор эмнэлгийн мэргэжилтэн ажилтнуудын сэтгэл ханамжийн судалгааг авах	Сэтгэл ханамжийн судалгаа хийсэн тоо	91,3%	91,4%	Залуу эмч нарын холбоо ТББ	ЗДТГ	Орон нутгийн төсөв
13.	Эрүүл мэндийн байгууллагуудын менежментийг сайжруулах чиглэлээр олон улсын чанарын тогтолцооны сургалтыг зохион байгуулах	Сургалтад хамрагдсан байгууллагуудын тоо	4	4	ЭМГ	Төрийн бус байгууллага	Улс болон орон нутгийн төсөв
14.	Эрүүл мэндийн салбарын 30-с дээш насны эмэгтэй ажилчдыг умайн хүзүүний хавдрын эрт илрүүлэг, ServiCare AI оношилгоонд хамруулах -Бүдүүн гэдэсний дуран шинжилгээ /45+насныхан/	Шинжилгээнд хамрагдсан ажилчдын тоо	93%	93%	ЭМБ-ууд	Аймгийн ЭМБ-уудын ҮЭХ	7,000,000
15.	Эрүүл мэндийн ажилчдын чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх чийрэгжүүлэлт болон амрах өрөөг засаж тохижуулах.	Тохижуулсан танхимын тоо	12	14	ЭМБ-ууд	ЭМГ, ЗДТГ, хандивлагч байгууллагууд	Төрийн болон хувийн хэвшлийн ЭМБ-ууд
16.	Эрүүл мэндийн байгууллагуудын ахмадуудад хүндэтгэл үзүүлэх, цаг үеийн мэдээллээр хангах	Сургалт мэдээлэлд хамрагдсан хувь	20%	25%	ЭМГ	ЗДТГ, Эрүүл мэндийн байгууллагууд	Төрийн болон хувийн хэвшлийн ЭМБ-ууд
17.	Аймгийн "Тэргүүний эрүүл мэндийн ажилтан" сонгон шалгаруулж урамшуулах	Шалгарсан эрүүл мэндийн ажилтны тоо	2	1	ЭМГ	ЗДТГ, Эрүүл мэндийн байгууллагууд	Орон нутгийн төсөв
18.	Дэмжлэгийн сан	Дэмжлэгт хамрагдсан эрүүл мэндийн ажилтны тоо	58	60	ЭМГ	ЗДТГ, Эрүүл мэндийн байгууллагууд	30,000,000
Нийт дүн							130.0 сая төгрөг